

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ТОРГУУЛИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВЬЖ БАЙГАА БОЛОВЧ
ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ, ОЛОН НИЙТИЙН
ОРОЛЦООГ ХАНГАХ, ХЯНАЛТ ТАВИХ ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮҮ, ТОРГУУЛИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: ГСА-2024/27-6-ШТА-ГА

Говьсүмбэр аймаг

2025 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр, Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: Darkhanbatb@audit.gov.mn

Аудитор: Б.Соёлмаа, Утас: 70543179
Цахим хаяг: soyolmaaba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газарДарга, тэргүүлэх аудитор
Б.СарантуяаАудитын менежер
Г.НаранбаярАхлах аудитор
Б.Дарханбат

Аудитор

Б.Соёлмаа

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2025 оны 7 дугаар сар

ТОВЧИЛСОН ҮГС 3

А. Торгуулийн орлогыг бодитой төлөвлөх боломжгүй боловч орлого давсан шалтгаан нөхцөлийг тодорхойлж дүгнээгүй, хууль эрх зүйн орчны уялдаа холбоо хангалтгүйгээс орон нутгийн төсөвт төвлөрөх боломжтой байсан 27.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ. 8

А.1. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хүүгийн орлогыг төлөвлөөгүй боловч торгуулийн орлогыг төлөвлөлт хийх үеийн нөхцөл байдалд үндэслэн төлөвлөсөн байна. 8

А.2. Торгуулийн орлого жил бүр баталсан төлөвлөгөөнөөс 39-78 хувиар давж биелсэн боловч орлого давж байгаа шалтгаан нөхцөлийг дүгнээгүй, сумдын төсөвт торгуулийн орлогыг төлөвлөөгүй байна. 8

А.3. Торгуулийн орлогын хууль эрх зүйн орчны уялдаа холбоог сайжруулж, Төсвийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна. 11

Б.Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан торгуулийн орлогын 87 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна. 15

Б.1. 2023,2024 онд торгох шийтгэл оногдуулсан торгуулийн орлогын 87 хувь нь төсөвт төвлөрсөн бөгөөд торгуулийн орлогын төлөвлөгөө жил бүр 39-78 хувиар давж биелсэн байна. 15

Б.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу хуваарилаагүй байна. 18

В. Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төсвийг хуваарилсан бөгөөд батлагдсан төсвийн 92 хувийг зориулалтын дагуу зарцуулсан байна. 20

В.1. Аймаг, сумын ГХУСАХЗ-аас гадаад, дотоод туршлага судлах, тэмцээн уралдаан зохион байгуулах арга хэмжээнд 34.3 сая төгрөгийг зарцуулсан байна. 20

В.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг Шилэн дансны цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн байна. 23

Г. Торгуулийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, орлогын бүрдүүлэлтэд эрх бүхий байгууллага албан тушаалтан хяналт тавьж байгаа боловч зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, иргэд олон нийт хяналт тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна. 24

Г.1. Торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангүй байгаагаас төрийн байгууллага бүр тус тусдаа мэдээллийн сан бүрдүүлсэн байна. 24

Г.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлтэд эрх бүхий байгууллага албан тушаалтан хяналт тавьж байгаа боловч, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, иргэд олон нийт хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна. 25

Дүгнэлт

Зөвлөмж

Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Тайлан баталгаажуулах тушаал

ТОВЧИЛСОН ҮГС

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
АТҮТ	Авто тээврийн төв
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ГХЗУСТХ	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
ГХУСАЗСЗ	гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ГХУСАХЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СЯ	Сангийн яам
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их хурал
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ХГБХХГ	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМГ	Эрүүл мэндийн газар
ЭЭХХЗГ	Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрх, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2024 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Нийслэл дэх Төрийн аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө хөтөлбөр, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт өгч зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тухай хууль;
- Автозамын тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль;
- Улсын бүртгэлийн тухай хууль;
- Иргэний хууль;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Засгийн газрын 2020 оны 107 дугаар тогтоолоор баталсан “Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажиллах журам”;
- Засгийн газрын 2021 оны 135 дугаар тогтоолоор баталсан “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журам”;
- Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар баталсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Бусад холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актууд.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад хүү, торгуулийн орлого төлөвлөх, бүрдүүлэх, зарцуулах, хяналт хэрэгжүүлдэг төрийн байгууллагууд болох аймгийн АЗДТГ-ын СТСХ, Татварын газар, АИТХ-ын ГХУСАЗЗ, зөрчлийн тухай хуулиар торгууль оногдуулах эрх бүхий албан тушаалтнуудын холбогдох чиг үүргийн хэрэгжилт, 2023, 2024 онд хүү, торгуулийн орлогыг бүрдүүлсэн байдал, зарцуулалт, тайлан мэдээ, дансны хуулга, бусад нотлох баримт, материалыг хамруулсан.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000-д нийцүүлэн боловсруулсан Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, Монгол улсын Ерөнхий аудиторовын А/106 дугаар тушаалаар баталсан 2020 оны “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан,

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Хүндрэл бэрхшээл:

тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, түүвэрлэлт хийх, тухайн асуудал хариуцсан албан тушаалтнаас асуулга лавлагаа, тодруулга авах зэрэг горимыг хэрэгжүүлж түүнд үндэслэн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг, Б.Соёлмаа нар хийж гүйцэтгэлээ.

Аудитын нээлтийг 2025 оны 06 дугаар сарын 04-нд хийж, гүйцэтгэлийн үе шатны ажлыг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл гүйцэтгэж, тайланг 07 дугаар сарын 31-ний дотор боловсруулан, тайланг дарга, Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулан холбогдох байгууллага, албан тушаалтанд 2025 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хүргүүлжээ.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2, 23.9.2 дахь хэсэгт “... хүү, торгуулийн орлого” нь аймаг, нийслэл болон улсын зэрэглэлтэй хот, сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлогод хамаарахаар зохицуулагдсан. Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар баталсан төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу татварын бус орлогын нийтлэг татварын бус орлогод хамаарч “хүү, торгуулийн орлого” гэсэн ангиллаар орон нутгийн төсвийн гүйцэтгэлд тайлагнагдаж байна. Төсвийн орлогын ангиллыг 2023, 2024 оноор харьцуулан харуулбал:

Орлогын төрөл	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар
Татварын орлого	9,283.8	10,865.3	117%	12,607.6	15,288.9	121%
Татварын бус орлого	1,334.0	1,722.1	129%	1,888.8	2,845.5	151%
Нийт	10,617.8	12,587.4	119%	14,496.4	18,134.4	125%

Орон нутгийн хэмжээнд хүү, торгуулийн орлогын бүрдүүлэлт

Татварын бус орлогын нэр төрөл	2023 он			2024 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт хувиар
Хүү, торгуулийн орлого	900.0	1,251.4	139%	1,362.2	2,430.5	178%
Түрээсийн орлого	60.0	51.2	85%	54.0	42.3	78%
Төсөвт байгууллагын өөрийн орлого	90.7	70.3	78%	85.7	90.1	105%
Сумдын ХХС орлого	283.3	268.8	95%	386.9	236.7	61%
Бусад орлого	0.0	80.4		-	51.5	
Нийт	1,334.0	1,722.1	129%	1,888.8	2,845.5	151%

Аудитын
хязгаарлалт

Хүү торгуулийн орлого нь татварын бус орлогын 78-85 хувь, аймгийн төсвийн орлогын 10-13 хувийг бүрдүүлж байна. Мөн өмнөх оны гүйцэтгэлээс 194 хувиар нэмэгджээ. Торгуулийн орлогын төвлөрүүлэлтийг бусад аймгуудтай харьцуулж үзвэл 2024 оны байдлаар 10 дугаарт байна.

Аудитаар зөвхөн Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулж төсөвт төвлөрүүлсэн орлогыг хамруулсан бөгөөд Эрүүгийн хуулиар оногдуулсан торгох ял шийтгэл болон бусад хэлбэрээр төлүүлсэн торгуулийг хамруулаагүй болно. Говьсүмбэр аймаг дахь ШШГГ 425-р нээлттэй хорих ангиас 2023 онд 327.4 сая, 2024 онд 934.1 сая төгрөгийг аймгийн нэр заагдаагүй бусад орлого дансанд төвлөрүүлсэн байна. Мөн Сум хөгжүүлэх сангийн хүүгийн орлогыг аудитад хамруулаагүй.

Дүрслэл товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	ЭБАТ-нуудаас авсан санал асуулга	11
Дүрслэл 2	Торгуулийн орлого бүрдүүлж буй хууль тогтоомж	17
Дүрслэл 3	Нийт орлого ба торгуулийн орлогын хамаарал	18

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Торгуулийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	8
Хүснэгт 2	Торгуулийн орлогын төлөвлөлт	9
Хүснэгт 3	Хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	
Хүснэгт 4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	9
Хүснэгт 5	Аймаг сумдын төрийн санд бүртгэлтэй хүү, торгуулийн орлогын данс	11
Хүснэгт 6	Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан байгууллагын жагсаалт	13
Хүснэгт 7	2023,2024 онд торгох шийтгэл оногдуулаагүй байгууллага ЭБАТ-ны жагсаалт	14
Хүснэгт 8	Улсын төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлого	14
Хүснэгт 9	ЭБАТ-нуудаас 2023, 2024 онд илрүүлж торгох шийтгэл оногдуулсан зөрчлийн хэргийн тоо, мөнгөн дүн	15
Хүснэгт 10	Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл он тус бүрээр	16
Хүснэгт 11	Торгуулийн орлого төвлөрүүлсэн дансны мэдээлэл	17
Хүснэгт 12	аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлого, торгуулийн орлого	18
Хүснэгт 13	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлөвлөлт	19
Хүснэгт 14	2024 онд Сангийн яамнаас хянасан болон АИТХ-аар баталсан зардлын хуваарилалт	20
Хүснэгт 15	ГХУСАХЗ-ын батлагдсан төсөв, гүйцэтгэл	20
Хүснэгт 16	ГХУСАХЗ-ыг 46.1-т заасан зориулалт	21
Хүснэгт 17	ГХУСАХ-нд зарцуулсан төсвийн хөрөнгийг ГХЗУСТХуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дах хэсэгт заасан зориулалт	22
Хүснэгт 18	Цахим системээр төлөгдсөн торгуулийн тоо	25

БҮЛЭГ 1

А. Торгуулийн орлогыг бодитой төлөвлөх боломжгүй боловч орлого давсан шалтгаан нөхцөлийг тодорхойлж дүгнээгүй, хууль эрх зүйн орчны уялдаа холбоо хангалтгүйгээс орон нутгийн төсөвт төвлөрөх боломжтой байсан 27.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

А.1. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хүүгийн орлогыг төлөвлөөгүй, торгуулийн орлогыг төлөвлөлт хийх үеийн нөхцөл байдалд үндэслэн төлөвлөсөн байна.

А.1.1. Говьсүмбэр аймгийн төсөвт 2023, 2024 оны байдлаар хүүгийн орлогыг төлөвлөөгүй байна. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2¹, 23.9.2², Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.1.а³, 7.6.1.а⁴ гэж зааснаар хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн татварын бус орлогод хамаарч байна.

А.1.2. Торгуулийн орлого нь хууль тогтоомжид заасан төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр тул төлөвлөх хэрэгцээ шаардлага байна. Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.1.а⁵, 7.6.1.а⁶ гэж заасны дагуу торгуулийн орлогыг орон нутгийн төсвийн төсөлд төлөвлөхөөр заасан бөгөөд аймгийн ТЕЗ-аас 2023 онд 900.0 сая, 2024 онд 1,362.2 сая төгрөгийг төлөвлөж аймгийн ИТХ-аар баталсан нь аймгийн нийт төсвийн орлогын 10 орчим хувийг эзэлж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5⁷-т заасны дагуу хяналт, шалгалтын байгууллага нь орлого төвлөрүүлэх үүрэг хүлээхгүй гэж заасан тул Говьсүмбэр аймагт Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулах 25 байгууллага торгуулийн орлогыг төлөвлөөгүй, аймгийн ТЕЗ-аас торгуулийн орлогыг төлөвлөж Сангийн ямаар хянуулж, АИТХ-аар батлуулжээ.

А.2. Торгуулийн орлого жил бүр баталсан төлөвлөгөөнөөс 39-78 хувиар давж биелсэн боловч орлого давж байгаа шалтгаан нөхцөлийг дүгнээгүй, сумдын төсөвт торгуулийн орлогыг төлөвлөөгүй байна.

А.2.1. Торгуулийн орлогыг сумдын төсөвт төлөвлөөгүй, зөвхөн аймгийн ТЕЗ-ийн төсөвт төлөвлөсөн бөгөөд жил бүр батлагдсан төлөвлөгөөнөөс 39-78 хувиар давж биелсэн байна.

Хүснэгт 1 Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл (сая төгрөгөөр)

Он	Тодотгож баталсан торгуулийн орлого	Жилийн эцсийн гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
2023	900.0	1,251.4	351.4	139%
2024	1,362.2	2,430.5	1,068.3	178%

(Эх сурвалж: ТЕЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, АИТХ-ын тогтоол)

А.2.2. Зөрчлийн болон Эрүүгийн тухай хуулиар торгох шийтгэл, ял оногдуулах эрх, үүрэг бүхий төрийн байгууллагуудын гүйцэтгэх чиг, үүрэг хууль эрх зүйн орчин харилцан адилгүй, зөрчил гарах цаг хугацаа, шалтгаан нөхцөлийг урьдчилан тогтоох боломжгүй, торгуулийн орлогыг хэрхэн төлөвлөх талаар заавар, аргачлал, зохицуулалтын дүрэм, журам байхгүйгээс төлөвлөлт хийхдээ өмнөх оны гүйцэтгэл болон тухайн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн төлөвлөдөг байна.

¹ 23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

² 23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

³ 7.5.1.а/ аймаг, нийслэлийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр;

⁴ 7.6.1.а/ сум, дүүргийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр;

⁵ 7.5.1.а/ аймаг, нийслэлийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр;

⁶ 7.6.1.а/ сум, дүүргийн төсвийн нийт орлогын дүнг Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан орлогын нэр, төрлөөр;

⁷ 9.5.Хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй.

Хүснэгт 2 Торгуулийн орлогын төлөвлөлт

(сая төгрөгөөр)

Он	Өмнөх оны гүйцэтгэл	Аймгийн санал /Торгууль/	СЯ-наас хянасан /Торгууль/	Аймгийн ИТХ-аар баталсан торгуулийн орлого	Тодотгож баталсан торгуулийн орлого
2023	870.1	840.3	840.0	900.0	900.0
2024	1,251.4	550.0	850.0	930.0	1,362.2

(Эх сурвалж: ТЕЗ-ийн 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, АИТХ-ын тогтоол, ТЕЗ-ийн төсвийн төсөл)

Аймгийн ТЕЗ-ийн Сангийн яаманд өргөн барьсан 2024 оны төсвийн төсөлд торгуулийн орлогыг өмнөх оны гүйцэтгэл болон тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс хэт бага буюу 550.0 сая төгрөгөөр батлуулах санал ирүүлснийг Сангийн яамнаас хянаж өмнөх оны түвшинд 850.0 сая төгрөгөөр баталсан бол АИТХ-аас 1,362.2 сая төгрөг болгон нэмэгдүүлж баталжээ. Энэ нь Сангийн яаманд орлого, зардлын хэмжээг багаар хянуулж, орон нутагт төсөв батлахдаа нэмэгдүүлж батлах сонирхол байдагтай холбоотой байна.

А.2.3. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хүүгийн орлогыг урьдчилан төлөвлөөгүй байна.

Хүснэгт 3 Хүүгийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	2023 он			2024 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан (тасарсан)	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Давсан /тасарсан/
1	Нийгмийн даатгалын сан /Төрийн банк, Хаан банкны 10 данс/	48.5	48.3	(0.2)	48.5	21.6	(26.9)
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425-р нээлттэй хорих анги /MN830034300000020133/	0	0	0	0	0.6	0.6
3	УСДУ ОНӨААТҮГ /300200011182/	0	0.2	0.2	0	0.5	0.5
4	Талын илч ОНӨААТҮГ /5994002056, 30010003681/	0	0	0	0	0.3	0.3
5	Илчлэг шивээ ОНӨААТГ/300300105581, 5992019798/	0	0.01	0.01	0	0.004	0.004
6	Тохижилт Сүмбэр ОНӨААТҮГ 300000411025-Хугацаагүй хадгаламжийн данс /Үндсэн/ 300000417636-Энгийн харилцах усны орлого 5990479622-Энгийн харилцах хогны орлого	0	0.05	0.05	0	0.012	0.012
Нийт дүн		48.5	48.6	0.1	48.5	23.0	-25.5

(Эх сурвалж: Аудитын судалгаа, дансны хуулга)

Хүснэгтээс харахад: Нийгмийн даатгалын сангийн хүүгийн орлого 26.7 сая төгрөгөөр буюу 55 хувиар тасарсан байна. Үүнд: Сангийн мөнгөн хөрөнгийн хэмжээ багасаагүй боловч арилжааны банкинд байрших хугацаа багасаж, төвлөрүүлэлтийн тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ. Тухайлбал 5990039294 тоот дансны төвлөрүүлэлтийн тоо 2023 онд 122 байсан бол 2024 онд 183 болж 1.5 дахин нэмэгдсэн байна.

ОНӨААТҮГ-ууд хүүгийн орлогыг төлөвлөдөггүй бөгөөд 2023, 2024 оны байдлаар нийт 1.07 сая төгрөгийн хүүгийн орлого бүртгэсэн байна.

А.2.4. Торгуулийн орлогоор санхүүжүүлэх зардлыг урьдчилан тооцсон байна. ГХЗУСТухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.3⁸-т заасны дагуу аймаг, сумын ИТХ-ын даргаар удирдуулсан орон тооны бус зөвлөл тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, 2023 онд 16

⁸ тухайн нутаг дэвсгэрийн төрийн захиргааны болон хууль сахиулах байгууллага, олон нийтийн оролцоотойгоор гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж, биелэлтийг хангах;

зорилт бүхий 107 арга хэмжээг 351.2 сая, 2024 онд 15 зорилт бүхий 107 арга хэмжээг 411.5 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр баталсан байна.

Хүснэгт 4. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Аймаг, сумын нэр	2023				2024			
		Зорилт	Арга хэмжээ	ГХУСАХ-ний төлөвлөгөөний төсөв	Батлагдсан төсөв	Зорилт	Арга хэмжээ	ГХУСАХ-ний төлөвлөгөөний төсөв	Батлагдсан төсөв
1	Шивээговь	3	26	5.0	5.0	3	27	24.0	24.0
2	Баянтал	3	39	5.0	5.0	3	36	5.0	5.0
3	Сүмбэр	6	9	15.0	25.0	5	10	32.0	32.0
4	Аймаг	4	33	326.2	326.2	4	34	352.0	352.0
Нийт		16	107	351.2	361.2	15	107	413.0	413.0

(Эх сурвалж: Аймгийн ГХУСАЗСЗ-ийн 2023, 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө)

Хүснэгтээс харахад хэрэгжүүлэхээр баталсан арга хэмжээний төсөв нь батлагдсан төсвөөсөө 2023 онд 10.0 сая төгрөгөөр бага байна. Аймгийн ГХУСАЗСЗ нь 2023 оны хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлахдаа арга хэмжээ бүрээр нь төсвийг төлөвлөөгүй бөөн дүнгээр нь төлөвлөж баталсан нь төлөвлөлт хангалтгүй байгааг харуулж байна. Мөн сумдын ГХУСАЗСЗ нь хуулийн 20 дугаар зүйлийн 20.2⁹-т заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хийхдээ гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдал, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай уялдуулж төлөвлөлт хийгээгүй байх тул зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг сумдын ГХУСАЗСЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв.

A.2.5. Торгуулийн орлогын төлөвлөгөөнөөс давсан нөхцөл байдлыг үнэлж, дүгнээгүй байна. Торгуулийн орлогын төлөвлөгөө /хүснэгт 1-т харуулсан/ 2023 онд 38 хувь буюу 351.4 сая, 2024 онд 78 хувь буюу 1,068.3 сая төгрөгөөр давж биелсэн байна. Аудитаар торгуулийн орлого давсан шалтгааныг дүгнэж үзэхэд дараах байдалтай байна.

- Говьсүмбэр аймаг дахь ШШГГ 425-р нээлттэй хорих ангиас төвлөрүүлсэн Эрүүгийн хуульд заасан хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн шийтгэлийн мөнгөн хөрөнгө өмнөх оноос 2.8 дахин нэмэгдсэн нь нөлөөлсөн байна. Тухайлбал ШШГГ 425-р нээлттэй хорих ангиас тус дансанд 2023 онд 327.4 сая, 2024 онд 934.1 сая төгрөгийг аймгийн нэр заагдаагүй бусад орлого дансанд төвлөрүүлжээ. 2024 онд төвлөрүүлсэн нийт мөнгөн хөрөнгийн 734.3 сая төгрөг буюу 78.6 хувь нь 1 хуулийн этгээдээс төлөгдсөн нь 1 удаагийн шинжтэй орлого байна.
- Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн замын болон хэв журмын торгуулийн орлого өмнөх оноос 420.0 сая төгрөгөөр буюу 1.6 дахин нэмэгдсэн нь торгуулийн орлого төлөвлөгөөнөөс давах шалтгаан болсон байна.

Мөн аймгийн СТХС-ээс орлого давж байгаа шалтгаан нөхцөлийг дүгнээгүй бөгөөд зөвхөн гүйцэтгэлд үндэслэн төлөвлөж байгаа нь орлогын төлөвлөгөөг хэт өндрөөр төлөвлөх үүнээс шалтгаалж зөрчлөөс урьдчилан сэргийлэх бус торгох шийтгэл оногдуулах, хяналт шалгалтын давтамж нэмэгдсэнээр иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд дарамт болж хувирах гэх мэт сөрөг үр дагаврыг нийгэмд бий болгож болзошгүй байна.

⁹ 20.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгцээ, шаардлага, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашдын төлөв байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна.

Цаашид торгуулийн орлогын төлөвлөлтийг хийхдээ төлөгдөх нь тодорхой болсон, шүүхээр шийдвэрлэгдсэн торгуулийн судалгааг эрх бүхий байгууллага албан тушаалтнаас гаргуулан авч төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

А.2.6. Сүмбэр, Шивээговь, Баянтал сумын төсвийн орлогын эх үүсвэрт торгуулийн орлогыг төлөвлөөгүй байна. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3¹⁰, 22.6.4¹¹, 23 дугаар зүйлийн 23.9¹², 23.9.2¹³ заасны дагуу төсвийг төсвийн ангилал, төсөв захирагч бүрээр нь төлөвлөх, батлах, тайлагнах хуулийн зохицуулалттай байна. Дээрх хуулийн заалтаар торгуулийн орлого нь аймаг болон сумын татварын бус орлогод хамаарах боловч зөвхөн аймагт торгуулийн орлогыг төлөвлөжээ.

Хүснэгт 5 Аймаг сумдын төрийн санд бүртгэлтэй хүү, торгуулийн орлогын данс

№	Аймаг, сумын нэр	Дансны нэр	Дансны дугаар
1	Аймаг	Гс.Хүү, торгуулийн орлого	100220000988
2	Сүмбэр	Гс.Сү.Хүү, торгуулийн орлого	100220500988
3	Шивээговь	Гс.Ши.Хүү, торгуулийн орлого	100220300988
4	Баянтал	Гс.Ба.Хүү, торгуулийн орлого	100220400988


(Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн дансны төлөвлөгөө)

Цаашид Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж сумын орон нутгийн төсөвт торгуулийн орлогыг төлөвлөх, тухайн зөрчлийг шийдвэрлэсэн газар нутгийн байршлаар нь харьяа төрийн сангийн дансанд орлогыг төвлөрүүлж ажиллах зөвлөмжийг аймаг, сумдын Засаг дарга, Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргад хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.3. Торгуулийн орлогын хууль эрх зүйн орчны уялдаа холбоог сайжруулж, Төсвийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

А.3.1. Зөрчлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3.1.1¹⁴, 3.4.1¹⁵-т заасны дагуу зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд шүүх, эрх бүхий албан тушаалтнаас торгох шийтгэл оногдуулна, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5¹⁶-т ЭБАТ нь шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ хэрэгжилтийг хариуцна гэж заасан байна. Дүрслэл 1

Торгох шийтгэл оногдуулах 20 байгууллагын 21 эрх бүхий албан тушаалтнуудтай уулзалт хийж, санал асуулга авсан бөгөөд торгууль оногдуулж буй хууль эрх зүйн орчин нь бодит хэрэгцээ шаардлагыг хангаж байна уу гэсэн асуултад 15 буюу 72 хувь нь үгүй гэж хариулжээ.



¹⁰ 22.6.3.төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;

¹¹ 22.6.4.төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;

¹² 23.9.Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

¹³ 23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

¹⁴ 1.1.торгох шийтгэл;

¹⁵ 1.Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.

¹⁶ 1.Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна.

А.3.2. Хүү бодох аргачлал, хугацаа, хүүгийн хувь хэмжээтэй холбоотой харилцааг Иргэний тухай хууль, Төв банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Монгол банкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2023.05.23-ны өдрийн А/106/298 тоот тушаалаар баталсан “Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, зээлийн хүүгийн хэмжээг бодох, тооцох, мэдээллийн ил тод байдлыг хангах аргачлал”-ын дагуу зохицуулж байна.

А.3.3. Тодорхойгүй маргаантай заалтууд орлого бүрдүүлэлтэд сөргөөр нөлөөлж байна. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2¹⁷, 23.9.2¹⁸-т зааснаар торгуулийн орлого нь орон нутгийн төсөвт хамаарахаар заасан. Харин Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1¹⁹, 4.1.3²⁰-т торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх хуулийн зохицуулалттай байна. Хууль тогтоомжууд харилцан уялдаагүй байгаагаас ЭБАТ-ууд торгуулийн орлогыг улсын болон орон нутгийн төсөвт харилцан адилгүй төвлөрүүлсэн байна.

А.3.4. Торгуулийн хэмжээ нь зарим тохиолдолд үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй байна. Аудитаар 23 ЭБАТ-наас торгуулийн хэмжээ нь үйлдсэн зөрчилтэй нийцэж байна уу? гэсэн асуултад тийм гэж 3 буюу 13 хувь, үгүй гэж 19 буюу 82.6 хувь, мэдэхгүй гэж 1 буюу 0.4 хувь нь хариулжээ. Дараах зөрчилд оногдуулж буй торгуулийн арга хэмжээ нь үйлдсэн зөрчилтэйгээ бодит байдалд нийцэхгүй байна. Үүнд:

1. Зөрчлийн тухай хуулийн 5.14 дугаар зүйлд бусдад хор хохирол учруулсан эсэхийг харгалзахгүй өөрийн эд хөрөнгийг санамсар болгоомжгүй байдлаар гал алдаж шатаасан бол иргэнийг 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж байгаа нь бодит нөхцөл байдалд хэрэгжүүлэхэд хүндрэлтэй. Өөрөөр хэлбэл иргэн өөрийн эд хөрөнгөөрөө хохирсон байтал дахин торгууль төлж эдийн засгаараа хохирох нөхцөл байдалтай байна
2. Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлд хүүхдийг үл хайхрах, согтуурсан, мансуурсан хүчирхийлэл үйлдсэн бол 300 нэгжээр торгох заалт нь бодит нөхцөл байдалд хэрэглэхэд амьдралын боломж тааруу айлын өрхийн орлогод шууд нөлөөлөх, хүчирхийлэлд өртсөн хүүхдийн эрх зүйн байдлыг улам дордуулах үр дагавартай байна. Иймд торгохоос өөрөөр шийдвэрлэх /албадан хөдөлмөр эрхлэх, эмчилгээнд явуулах, соён гэгээрүүлэх гэх мэт/
3. Зөрчлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.21, 17.1.22, 17.1.23, 17.1.24, 17.1.25, 17.1.26-т заасан сонгуультай холбоотой зөрчилд зөрчлийн хэмжээ, учирсан хор хохирол зэргийг харгалзан үзэхгүйгээр иргэнийг 10000, хуулийн этгээдийг 100000 нэгжээр торгож байгаа нь бодит байдалд нийцэхгүй, Үндсэн хуулиар олгосон сонгох, сонгогдох эрхийг хязгаарлах эрсдэлтэй байна. Тухайлбал:
 - Сонгуулийн зардлын дансыг бүртгүүлээгүй, зардлын тайлангаа хуульд заасан хугацаанд ирүүлээгүй нь зөрчил боловч хандив аваагүй нам, нэр дэвшигчийг 10.0-100.0 сая төгрөгөөр торгох нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй.
 - Хуулиар хориглосон хандивыг буцаагаагүй нь зөрчил боловч 10.0 мянган төгрөгийн хандив буцаагаагүй байсан ч 10000 нэгж буюу 10.0 сая төгрөгөөр торгох нь үйлдсэн зөрчилтэй нь нийцэхгүй.
4. Зөрчлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1.9-т “1.9.өмчлөгч, эзэмшигч барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүйгээр үндсэн хийц, бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, эсхүл тухайн барилга байгууламжид байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн” зөрчилд иргэнийг

¹⁷ 23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

¹⁸ 23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

¹⁹ 4.1.1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана.

²⁰ 4.1.3.Хуульд өөрөөр заагаагүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

500 нэгж, хуулийн этгээдийг 5000 нэгжээр торгож байна. Нийтийн орон сууцны барилгын үндсэн хийц бүтээцийг нурааж, зориулалтыг өөрчилснөөр оршин суугч иргэдийн эрүүл мэнд, амь насанд асар их хор хохирол учруулж болохуйц нийтийн ашиг сонирхлын эсрэг зөрчилд 500-5000 нэгжээр торгох шийтгэл оногдуулж байгаа үйлдсэн зөрчилтэй нь харьцуулахад маш бага байна.

5. Зөрчлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т заасан Боловсролын тухай хуулийн зөрчилд оногдуулах торгуулийн хэмжээ иргэн 20, хуулийн этгээд 200 нэгж байгаа нь үйлдсэн зөрчилтэй нь харьцуулахад маш бага байна. Тухайлбал:

- Сурагчид сэтгэл санааны дарамт үзүүлсэн, хуульд заагаагүй төлбөр хураамж авсан зөрчил үйлдсэн
- Боловсролын стандарт, эсхүл сургалтын байгууллагад тавигдах шаардлагыг зөрчсөн
- Аж ахуйн нэгж, байгууллага нь ажилтанд бие дааж сурч боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх үүргээ биелүүлээгүй
- Багшийг ажил үүргээ гүйцэтгэхэд нь зориуд саад учруулсан
- Бага, дунд боловсролын сурах бичгийн боловсролын стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангуулаагүй гэх мэт

Зөрчилд оногдуулж буй торгох шийтгэл нь учирсан хор хохирлын хэмжээг харгалзан үздэггүй хор уршиг багатай зөрчилд хэт өндөр торгууль оногдуулдаг, /зөрчил бол зөрчил гэсэн байдлаар хуульчлагдсан/, зарим торгох шийтгэлийн хэмжээ хэт бага тул зөрчлүүд нь давтагдах шинжтэй, үүнээс шалтгаалж торгуулж буй иргэн, хуулийн этгээд нь торгууль бус зөвшөөрөл мэт ойлголттой болсон, ЭБАТ, Прокурор хохирлын хэмжээ, хор уршгийг харгалзан уян хатан байдлаар буюу тухайн нөхцөл байдалд тохируулан хуулийг хэрэглэх боломжгүй байдаг зэрэг нь торгуулийн хэмжээ үйлдсэн зөрчилтэй нийцэхгүй байхад нөлөөлөх хүчин зүйл болж байна.

А.3.5. Зөрчлийн тухай хуулийн 9.12-Музейн тухайн хууль зөрчих 9.12.3 “Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагын захирлыг томилох эрх бүхий албан тушаалтан хуульд заасан шаардлага хангаагүй албан тушаалтныг томилсон бол тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан байна. Энэ нь зөвхөн мэргэжлийн болон боловсролын салбарыг онцолсон бөгөөд бусад байгууллага, албан тушаалтны хууль бус томилгоонд дээрх заалт хамааралгүй байгаа нь тэгш бус байдлыг үүсгэх эрсдэлтэй байна.

Хүснэгт 6 Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан байгууллагын жагсаалт

№	Байгууллагын нэр	ЭБАТ-ын илрүүлсэн зөрчлийн тоо	
		2023 он	2024 он
1	Цагдаагийн хэлтэс	25,588	31,549
2	Онцгой байдлын газар	1	6
3	Улсын бүртгэлийн хэлтэс	19	107
4	Говьсүмбэр аймаг дахь ШШГГ 425-р нээлттэй хорих анги	2	0
5	Татварын газар	1	41
6	Байгаль орчны газар	0	16
7	ГХБХБГазар	3	23
8	Сүмбэр ЗДТГ	1	4
9	Гадаадын иргэн харьяатын газар	0	10
10	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	1	3
11	АТҮТөв	11	0
12	Мал эмнэлгийн газар	14	5
13	Хүнс хөдөө аж ахуйн газар	0	2
14	ЭЭХХЗГ	0	3
15	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	0	1
16	Эрүүл мэндийн газар	4	5
Нийт дүн		25,645	31,775

(Эх сурвалж: Аудитын судалгаа)

Хүснэгтээс харахад: 14 байгууллагын ЭБАТ-нууд 2023 онд 25645, 2024 онд 31775 зөрчил илрүүлж торгох шийтгэл оногдуулсан бөгөөд үүний 99.3-99.7 хувь нь цагдаагийн торгууль эзэлж байна. Зөрчлийн хэмжээ өмнөх оноос 23.9 хувиар нэмэгдэхэд цагдаагийн байгууллагын илрүүлсэн зөрчлийн тоо нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Хүснэгт 7. 2023, 2024 онд торгох шийтгэл оногдуулаагүй байгууллага ЭБАТ-ны жагсаалт

№	Байгууллагын нэр	ЭБАТ-ны тоо
1	Боловсролын газар	2
2	Нийгмийн даатгалын газар	2
3	Статистикийн хэлтэс	1
4	Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар	2
5	Аймгийн Засаг даргын Тамгын газар /Цэргийн штаб-1, ШӨТХГ-1, Архивын тасаг-1, СТСХ-2, ХБТХОХ-1/	6
6	Стандарт хэмжил зүйн хэлтэс	2
7	Умард говийн гүвээт халхын дундад талын сав газрын захиргаа	2
Нийт		17

(Эх сурвалж: Аймгийн Прокурорын газрын мэдээ, аудитын судалгаа)

Шийтгэл оногдуулаагүй 7 байгууллагын ЭБАТ-нуудаас шалтгааныг тодруулахад:

1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар албан шаардлага өгч арилгах боломжтой зөрчилд торгууль оногдуулаагүй.
2. Зөрчлийн тухай хуульд зөрчлийн хор хохирол, үр дагавар, нийгэм олон нийтэд үзүүлж буй нөлөөллийг харгалзан шийдвэрлэх заалт байдаггүй тул хэт өндөр торгууль тавигдах нь тухайн иргэн, хуулийн этгээдийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх үр дагавартай.
3. Зөрчлийн тухай хуульд заасан маш их процесс ажиллагаа хийсний үр дүнд бага торгууль оногдуулах нь үр дүн багатай тул Төрийн хяналт шалгалтын хуулиар зөрчил арилгах албан шаардлага өгч хэрэгжилтийг хангадаг гэж тайлбарласан байна.

ЭБАТ-нууд нь хууль эрх зүйн мэргэжилтэй мэргэшсэн албан хаагчид биш тул хуулийг харилцан адилгүй ойлгож, хэрэглэж байна. Тухайн албан хаагчийн эрх зүйн мэдлэг, ажлын ур чадвараас гадна албан тушаалын тодорхойлолтод гүйцэтгэх болон хяналт хэрэгжүүлэх чиг үүргийг давхар тусгаж өгсөн нь хууль хэрэглээ бүх нийтэд адил тэгш үйлчлэхгүй байхад нөлөөлж байна. Мөн МХГ 2023.01.01-ний өдрөөс татан буугдаж улсын байцаагч нар харьяалах салбартаа шилжсэн. Гэвч тухайн шилжиж очсон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг одоо болтол шинэчлээгүй байна. Үүнээс шалтгаалж тухайн байгууллагын зорилго, үйл ажиллагаа ЭБАТ-ны албан тушаалын тодорхойлолттой нийцэхгүй байх эрсдэл үүсжээ.

A.3.6. Төсвийн тухай хуулиар торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогод хамаарах боловч 2023-2024 онд 8 байгууллага 27.5 сая төгрөгийн торгуулийг улсын төсөвт төвлөрүүлжээ. Зөрчлийн тухай хуулиар торгуулийг улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан нь хууль хоорондын уялдаагүй байдал орлого бүрдүүлэлтэд нөлөөлөх шалтгаан болж байна.

Хүснэгт 8 Улсын төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлого

(сая төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	ЭБАТ-ын илрүүлсэн зөрчил, торгуулийн хэмжээ						Улсын төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлого
		2023 он			2024 он			
		Зөрчлийн тоо	Төлөх мөнгөн дүн	Төлөгдсөн дүн	Зөрчлийн тоо	Төлөх мөнгөн дүн	Төлөгдсөн дүн	
1	ГИХГ	0	-	-	10	3.8	3.8	3.8
2	ХГБХХГ	1	0.3	0.3	3	0.8	0.5	0.8
3	АТҮТөв	11	8.4	8.4	0	-	-	8.4
4	МЭГ	14	2.5	2.5	5	5.4	5.4	7.9
5	ХХААГ	0	-	-	2	0.6	0.6	0.6

6	ЭЭХХЗГ	0	-	-	3	1.0	1.0	1.0
7	ХХҮГ				1	5.0	5.0	5.0
8	ЭМГ	4	3.3	3.3	5	1.8	1.8	5.1
Нийт дүн		30	15	14.5	29	18	18.1	27.5

(Эх сурвалж: ЭБАТ-наас гаргуулж авсан аудитын судалгаа, дансны хуулга, баримт материал)

Цаашид зөрчил гарсан болон шалган шийдвэрлэсэн нутаг дэвсгэрийн төсвийн орлогын дансанд торгуулийн орлогыг төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзсэн тул Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

А.3.7. Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлийг 5.3 “Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно”, 16 дугаар зүйлийн 16.3 “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;”, Зөрчлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Хөрөнгө орлогыг хураах, шилжүүлэх” 4.2 “Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах” гэж заасан бөгөөд зөрчил гаргасан этгээдээс хохирлыг нөхөн төлүүлж үлдсэн хэсгийг улсын орлого болгох хуулийн зохицуулалттай байна. Зөрчлийн тухай хуульд хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хохирлыг нөхөн төлүүлэх зорилгоор өмчид халдаж байгаа нь Үндсэн хуульд заасан иргэний өмчийн халдашгүй байдалтай хамааралгүй гэж үзэж болохоор байна.

БҮЛЭГ Б

Б.Зөрчлийн тухай хуулиар торгох шийтгэл оногдуулсан торгуулийн орлогын 87 хувийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Б.1. 2023, 2024 онд торгох шийтгэл оногдуулсан торгуулийн орлогын 87 хувь нь төсөвт төвлөрсөн бөгөөд торгуулийн орлогын төлөвлөгөө жил бүр 39-78 хувиар давж биелсэн байна.

Б.1.1. Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.2²¹, 23.9.2²²-т заасны дагуу хүү, торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогод хамаарч байна. Аймгийн хэмжээнд 2023 онд 11 байгууллага 25,645 зөрчилд 704.5 сая төгрөг, 2024 онд 14 байгууллага 31,775 зөрчилд 1,151.1 сая төгрөгийн торгууль оногдуулж ажилласан байна. Үүнээс Цагдаагийн хэлтсийн газар дээр нь хялбаршуулсан зөрчилд оногдуулсан торгууль 230.2 сая төгрөг, Байгаль орчны газрын шүүхийн маргаантай 2 зөрчлийн 10.0 сая төгрөг, ХГБХХГ-ын 0.3 сая төгрөгийн торгуулийн орлого төсөвт төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 9 ЭБАТ-нуудаас 2023, 2024 онд илрүүлж торгох шийтгэл оногдуулсан зөрчлийн хэргийн тоо, мөнгөн дүн

№	Байгууллагын нэр	ЭБАТ-ны илрүүлсэн зөрчил						Төлөгдөөгүй үлдэгдэл		Төвлөрүүлсэн данс
		2023 он			2024 он			2023 он	2024 он	
		Зөрчлийн тоо	Төлөх мөнгөн	Төлөгдсөн дүн	Зөрчлийн тоо	Төлөх мөнгөн дүн	Төлөгдсөн дүн	Мөнгөн дүн	Мөнгөн дүн	
1	Цагдаагийн хэлтэс	25,588	686.0	606.2	31,549	1,055.4	905.0	79.8	150.4	Орон нутаг
2	Онцгой байдлын газар	1	0.1	0.1	6	1.7	1.7	-	-	
3	Улсын бүртгэлийн хэлтэс	19	0.4	0.4	107	3.2	3.2	- 0.0	-	
4	Говьсүмбэр аймаг дахь ШШГГ 425-р нээлттэй хорих анги	2	0.4	0.4	0	-	-	-	-	

²¹ 23.7.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

²² 23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

5	Татварын газар	1	1.5	1.5	41	25.0	25.0	-	- 0.0	
6	Байгаль орчны газар		-	-	16	25.9	15.9	-	10.0	
7	ГХБХБГазар	3	1.5	1.5	23	20.5	20.5	-	-	
8	Сүмбэр ЗДТГ	1	0.2	0.1	4	1.0	0.9	-	-	
9	Гадаадын иргэн харьяатын газар	0	-	-	10	3.8	3.8	-	0.0	Дорноговь аймаг
10	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар	1	0.3	0.3	3	0.8	0.5	-	0.3	Улсын төсөв
11	АТҮТөв	11	8.4	8.4	0	-	-	-	-	
12	Мал эмнэлгийн газар	14	2.5	2.5	5	5.4	5.4	-	-	
13	Хүнс хөдөө аж ахуйн газар	0	-	-	2	0.6	0.6	-	-	
14	ЭЭХХЗГ	0	-	-	3	1.0	1.0	-	-	
15	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар				1	5.0	5.0	-	-	
16	Эрүүл мэндийн газар	4	3.3	3.3	5	1.8	1.8	-	-	
Нийт дүн		25,645	705	624.7	31,775	1,151	990.3	79.8	160.7	

(Эх сурвалж: ЭБАТ-наас гаргуулж авсан аудитын судалгаа, дансны хуулга, баримт материал, холбогдох ЭБАТ-нуудтай хийсэн ярилцлага)

Хүснэгтээс харахад: 2023 онд оногдуулсан торгуулиас 79.8 сая, 2024 онд оногдуулсан торгуулиас 160.7 сая нийт 240.5 сая төгрөгийн торгууль төлөгдөөгүй буюу оногдуулсан торгуулийн 12.9 хувь төлөгдөөгүй байна. Нийт төлөгдөөгүй торгуулийн орлогын 95.7 хувийг цагдаагийн торгууль эзэлж байна.

Хүснэгт 10 Торгуулийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг он тус бүрээр харуулбал:

(сая төгрөгөөр)

№	Он	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	2023	900.0	1,251.4	(351.4)
2	2024	1,362.2	2,430.5	(1,068.3)
Нийт дүн		2,262.2	3,681.9	(716.9)

(Эх сурвалж: 2023, 2024 онуудын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлан)

Хүснэгтээс харахад: Торгуулийн орлого 2023 онд 39 хувиар, 2024 онд 78 хувиар тус тус төлөвлөгөөнөөс давж биелсэн байна.

Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн торгуулийн орлогыг нэр төрлөөр нь үзэхэд Зөрчлийн тухай хуулийн дагуу Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан оногдуулсан торгууль, Эрүүгийн хуулийн дагуу шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулан төсөвт төвлөрүүлсэн орлого, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу холбогдох байгууллагаас тогтоосон актын төлбөр, бусад нэр заагдаагүй орлогоос бүрдсэн байна. Дүрслэл 2



Б.1.2. Торгуулийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан оногдуулсан байна. Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын мэдээгээр аймгийн хэмжээнд 25 байгууллагын 116 ЭБАТ-ны орон тоо бүртгэлтэй байна. Үүнээс 60 буюу 57.2 хувь Цагдаагийн хэлтсийн алба хаагчид байна.

2024 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 14 байгууллагын 64 ЭБАТ торгох шийтгэл оногдуулсан бол 9 байгууллагын 20 ЭБАТ торгох шийтгэл оногдуулаагүй, 2 байгууллагын 5 ЭБАТ нууцын зэрэглэлд хамаарах болон Дорноговь аймгийн харьяанд байна. Прокурорын байгууллага Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1²³ болон

²³ 2.1.1. зөрчлийн хэрэг бүртгэлт хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;

Прокурорын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1²⁴-т заасны дагуу ЭБАТ-ны оногдуулж буй зөрчлийн хэрэгт прокурор тогтмол хяналт тавьж ажилладаг тул торгууль тавих эрхгүй байгууллага, албан тушаалтан торгох шийтгэл оногдуулах боломжгүй байна.

Б.1.3. Торгуулийн орлогыг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төрийн сангийн холбогдох орлогын дансанд төвлөрсөн гүйцэтгэлээр нь буюу мөнгөн сууриар тайлагнасан байна. Аймгийн торгуулийн орлогыг 2023 онд аймгийн төвийн төрийн сангийн 8 данс 1,251.4 сая төгрөг, 2024 онд аймгийн төвийн төрийн сангийн 7 данс, Сүмбэр сумын 1 данс, Шивээговь сумын 1 данс, Баянтал сумын 1 данс нийт 10 дансаар 2,430.5 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийснийг ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хүү, торгуулийн орлого дансанд бүртгэсэн байна.

Хүснэгт 11 Торгуулийн орлого төвлөрүүлсэн дансны мэдээлэл :

(сая төгрөгөөр)				
№	Дансны нэр	Дансны дугаар	2023 он	2024 он
1	Гс.Татварын торгууль	100220000952	11.6	50.7
2	Гс.Татварын алданги	100220000956	7.0	3.9
3	Гс.Төсөвт газрын өөрийн орлого	100220000954	55.9	105.6
4	Гс.Бусад нэр заагдаагүй орлого	100220000955	459.5	1,008.2
5	Гс.МХГ-орлого	100220000982	15.0	98.2
6	Гс.ЦХ-н хүү торгуулийн орлого	100220000985	173.0	200.4
7	Гс.ЗЦ-н хүү торгуулийн орлого	100220000987	0.4	-
8	Гс.Цагдаа Хүү, торгуулийн орлого	100220000988	529.0	922.0
9	Гс.Ши Татварын торгууль	100220300952	-	32.8
10	Гс.Ба Татварын торгууль	100220400952	-	3.1
11	Гс.Сү Татварын торгууль	100220500952	-	5.6
Нийт дүн			1,251.4	2,430.5

Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1²⁵, 26.2²⁶, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1²⁷-т заасны дагуу аккруз сууриар бүртгэл хөтлөнө гэж заасан. Харин торгуулийн орлогыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа төрийн сангийн дансанд төвлөрсөн гүйцэтгэлээр нь буюу мөнгөн сууриар бүртгэж байна. Мөн Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5²⁸-т хяналт, шалгалтын байгууллага нь орлого төвлөрүүлэх үүрэг хүлээхгүй гэж заасан тул төсвийн байгууллагууд бүртгэл тайландаа торгуулийн орлогыг тусгадаггүй байна. Торгуулийн орлогыг аккруз сууриар бүртгэснээр барагдуулалт, бүртгэл тайлагнал сайжрах үр нөлөөтэй байна.

Б.1.4. Хүү, торгуулийн орлого бүрдүүлэлт нь төсвийн орлогын бусад эх үүсвэрт нөлөөлж байна. 2021-2024 оны хооронд аймгийн төсвийн нийт орлогын хэмжээ 78 хувиар нэмэгдсэн бол торгуулийн орлогын хэмжээ 2.1 дахин нэмэгдсэн байна. Энэ нь цагдаагийн торгуулийг бэлэн бус системээр ногдуулж, хяналтын тогтолцоо сайжирч барагдуулалт нэмэгдсэн нь нөлөө үзүүлжээ.

Хүснэгт 12. Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн орлого, торгуулийн орлого

Он	Нийт орлого (сая.₮)	Торгууль (сая.₮)	Эзлэх хувь (%)
2021	10,178.4	1,152.1	11.3%
2022	9,807.8	870.1	8.9%
2023	12,531.9	1,251.3	10.0%
2024	18,134.7	2,430.5	13.4%

(Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2021, 2022, 2023, 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан)

²⁴ 12.1.1.зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг бүртгэх, зөрчлийн хэрэгт дугаар олгох;

²⁵ 26.1.Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккруз суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.

²⁶ 26.2.Төсвийн бүртгэлийг тохируулсан аккруз сууриар бүртгэж, тайлагнана.

²⁷ 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруз сууриар хөтөлнө.

²⁸ 9.5.Хяналт шалгалтын байгууллага улсын болон орон нутгийн төсөвт орлого оруулах үүрэг хүлээхгүй.

Дүрслэл 3 Нийт орлого ба торгуулийн орлогын хамаарал

Төсвийн орлого болон торгуулийн орлогын корреляцийн хамаарлыг үзэхэд дараах үр дүн гарч байна.



Графикаас харахад нийт орлого болон торгуулийн орлогын корреляцийн хамаарал 0.98 буюу маш хүчтэй хамааралтай байна.

Торгуулийн орлого төлөвлөсөн дүнгээс жил бүр давж биелж байгаа нь тасарсан орлого, эх үүсвэрийн дутагдлыг нөхөх, үүнээс шалтгаалж бусад орлого нэмэгдүүлэх эх үүсвэрийг бүрэн дайчлахгүй байх эрсдэлтэй байна.

Б.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу хуваарилаагүй байна.

Б.2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу Эрүүгийн тухай хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял болон Зөрчлийн тухай хуульд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40-өөс доошгүй хувийг дараагийн жилийн төсөвт тусган гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах хуулийн зохицуулалттай бөгөөд аймгийн Засаг даргаас өргөн барьсан 2023, 2024 оны төсвийн төсөлд ГХУСАХЗ-ын хэмжээг бөөн дүнгээр нь тусган АИТХ-аар батлуулсан байна.

Хүснэгт 13. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын төлөвлөлт

№	Сумын нэр	2023 он					2024 он				
		Торгуулийн орлогын өмнөх оны гүйцэтгэл	ГХЗУСТХуулийн 46 дугаар зүйлд заасан хувь хэмжээ	АИТХ-аар баталсан зардлын мөнгөн дүн	Сумын төсвөөс нэмсэн	Нийт багтагдсан үүсвэр	Торгуулийн орлогын өмнөх оны гүйцэтгэл	ГХЗУСТХуулийн 46 дугаар зүйлд заасан хувь хэмжээ	ИТХ-аар баталсан зардлын мөнгөн дүн	Сумын төсвөөс нэмсэн	Нийт багтагдсан үүсвэр
1	Говьсүмбэр	870.1	348.0	326.3		326.3	1,251.4	500.5	352.0		352.0
2	Сүмбэр			10.0	15.0	25.0			10.0	22.0	32.0
3	Шивээговь			5.0		5.0			5.0	19.0	24.0
4	Баянтал			5.0		5.0			5.0		5.0
Нийт		870.1	348.0	346.3	15.0	361.3	1,251.4	500.5	372.0	41.0	413.0

(Эх сурвалж: ТЕЗ-ийн 2022, 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит, АИТХ-ын тогтоол, ТЕЗ-ийн төсвийн төсөл)

АИТХ-аас хуваарилсан төсөв дээр 2023 онд Сүмбэр сум 15.0 сая, 2024 онд Шивээговь сум 19.0 сая, Сүмбэр сум 22.0 сая төгрөгийг сумын орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр нэмж

баталсан байна. Сумдын хувьд торгуулийн орлогыг төлөвлөж бүртгэдэггүй тул хуульд заасан доод хэмжээгээр тооцох боломжгүй байна.

ГХУСАХЗ-ын хэмжээг торгуулийн орлогын гүйцэтгэлээс тооцож үзвэл 2023 онд 1.7 сая, 2024 онд 128.5 сая төгрөгөөр тус тус дутуу тооцож хуваарилсан байна. Иймд аймгийн Засаг дарга буюу ТЕЗ-д хуульд заасан хамгийн доод хэмжээг баримтлан ГХУСАХЗ-ын хэмжээг төлөвлөж АИТХ-аар батлуулах зөвлөмжийг хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.2.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1²⁹, 46.3³⁰, 46.4-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэж заасан боловч хууль хэрэгжиж эхэлсэн 2020.01.01-ний өдрөөс хойш уг журам батлагдаагүй байна. Хууль эрх зүйн мэдээллийн Legalinfo.mn цахим хуудсанд Монгол Улсын хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998.04.10-ны өдрийн 88/152 дугаар тушаал хүчинтэй боловч 1997.12.05-ны өдрийн баталсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 онд хүчингүй болсноор хэрэгжих эрх зүйн чадамжгүй болжээ. Үүнээс шалтгаалж ГХУСАХЗ-ыг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах эрх зүйн орчин бүрдээгүй тул Нийслэл дэх төрийн аудитын газарт уламжлах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

Б.2.3. Зөрчлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7³¹-д заасан зөрчилд торгох шийтгэл оногдуулах, Авто замын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.4³²-т заасны дагуу торгуулийн орлогыг зардлын эх үүсвэрт хуваарилах хуулийн зохицуулалттай байна.

ГХЗУСТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1-т заасны дагуу торгуулийн орлогын 40-өөс доошгүй хувийг ГХУСАХЗ-д зарцуулахаар тодорхой хуульчилсан харин Авто замын тухай хуулийн дээрх заалтаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг зөрчсөн зөрчилд оногдуулсан цагдаагийн торгуулийн орлогын хэдэн хувийг Авто замын сангийн эх үүсвэрт төвлөрүүлэх нь тодорхойгүй байгаагаас хуваарилалтыг хэрхэн хийсэн нь мөн тодорхой бус байна. Иймд замын цагдаагийн торгуулийг 100 хувь авто замын санд төвлөрүүлэх үү эсвэл тодорхой хувь хэмжээгээр төвлөрүүлэх үү гэдгийг нарийн тусгаж өгөх шаардлагатай байх тул Нийслэл дэх Төрийн аудитын газарт уламжлах санал хүргүүлэхээр шийдвэрлэв.

2024 онд торгуулийн орлогоос санхүүжих ГХУСАХЗ, Авто замын сангийн зардлыг Сангийн яамнаас дараах байдлаар хянаж баталсан байна. Үүнд:

Хүснэгт 14 2024 онд Сангийн яамнаас хянасан болон АИТХ-аар баталсан зардлын хуваарилалт

№	ТАХ-нийн нэр	СЯ-наас хянаж баталсан	АИТХ-аар баталсан	Зөрүү
1	Авто замын сан	814.2	562.2	252.0
2	ГХУСАХЗ	66.7	372.0	(305.3)
Нийт дүн		880.9	934.2	(53.3)

(Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн төсөл, аудитын дүгнэлт, төсөв баталсан АИТХ-ын тогтоол)

²⁹ 46.1 зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд, 20-иос доошгүй хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд зориулан дараагийн жилийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.

³⁰ 46.3 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг аймаг, нийслэлийн батлагдсан төсөв дээр нь нэмж олгох замаар төвлөрүүлж, сум, дүүргийн Салбар зөвлөл, гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын төлөвийг харгалзан хуваарилж, зарцуулна

³¹ 14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих

³² 25.2.4.нийслэл, орон нутгийн авто зам дээр хөдөлгөөний аюулгүй байдлын зөрчил гаргасан, авто замын талаархи хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд ногдуулсан торгууль;

Хүснэгтээс харахад: Сангийн яамнаас хянаж УИХ-аар баталсан Авто замын сангийн эх үүсвэрээс 252.0 сая төгрөгийг ГХУСАХЗ-д шилжүүлсэн байна. Энэ нь Сангийн яам ГХУСАХЗ-ыг хуульд заасан хувиас бага дүнгээр баталсан тул аймгийн ИТХ-аас нэмж баталсантай холбоотой холбоотой байна.

Б.2.4. Аудитын явцад Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий 23 албан тушаалтнуудын албан тушаалын тодорхойлолттой танилцаж, ярилцлага хийсэн бөгөөд ЭБАТ-ны гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажил дүгнэх үзүүлэлтэд орлогын төлөвлөгөө биелүүлсэн байдал, төвлөрүүлсэн орлогын хэмжээг харгалзан үздэг үү? гэсэн асуултад 100 хувь үгүй гэж хариулсан байна.

БҮЛЭГ В

В. Торгуулийн орлогоос гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд төсвийг хуваарилсан бөгөөд батлагдсан төсвийн 92 хувийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

В.1. Аймаг, сумын ГХУСАХЗ-аас гадаад, дотоод туршлага судлах, тэмцээн уралдаан зохион байгуулах арга хэмжээнд 34.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

В.1.1. ГХУСАХЗ-нд зориулан баталсан зардлыг бүрэн зарцуулсан байна.

Хүснэгт 15. ГХУСАХЗ-ын батлагдсан төсөв, гүйцэтгэл

№	Аймаг, сумын нэр	2023			2024		
		Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Шивээговь	5.0	5.0	-	24.0	24.0	-
2	Баянтал	5.0	5.0	-	5.0	5.0	-
3	Сүмбэр	25.0	25.0	-	32.0	32.0	-
4	Аймаг	326.3	326.3	-	352.0	351.8	0.2
Нийт дүн		361.3	361.3	-	413.0	412.8	0.2

(Эх сурвалж: Аймгийн ТЕЗ-ийн 2024 оны төсвийн төсөл, аудитын дүгнэлт, төсөв баталсан АИТХ-ын тогтоол, аймаг, сумын ИТХ-ын санхүүгийн санхүүгийн тайлан, анхан шатны баримт, дансны хуулга)

Хүснэгтээс харахад ГХУСАХЗ-д батлагдсан нийт төсвийн 85-90 хувийг аймгийн ИТХ-ын ГХУСАЗСЗ зарцуулжээ.


Хүснэгт 16 ГХУСАХЗ-ыг 46.1-т заасан зориулалтаар нь ангилж үзвэл:

№	ҮЗҮҮЛЭЛТ	АЙМГИЙН ИТХ		СҮМБЭР СУМ ИТХ		ШИВЭЭГОВЬ СУМЫН ИТХ		БАЯНТАЛ СУМЫН ИТХ	
		2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он	2023 он	2024 он
1	Дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажил	108.0	18.3	6.7	13.3	0	18.9	0.4	0
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажил	218.2	333.5	18.3	18.7	5.0	5.1	4.6	4.9
НИЙТ ДҮН		326.2	351.8	25.0	32.0	5.0	24.0	5.0	4.9

(Эх сурвалж: Аймгийн сумын ГХУСАЗЗ-ийн шийдвэр, анхан шатны баримт, төлөвлөгөө тайлан)

ГХУСАХЗ-д хуульд заасан дүрс бичлэгийн техник, хэрэгсэл, зөрчил болон эрүүгийн хэрэг хянан шалгах байгууллагын мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах ажилд 2023 онд нийт зардлын 31.9 хувийг, 2024 онд 12.2 хувийг, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бусад ажилд 2023 онд 68.1 хувийг, 2024 онд 87.8 хувийг тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 17. ГХУСАХ-нд зарцуулсан төсвийн хөрөнгийг ГХЗУСТХуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дах хэсэгт заасан чиглэлээр задлан харуулвал:



(Эх сурвалж: Аудиторын ажлын баримт, анхан шатны баримт)

Гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгтэй байгууллагуудын техник хэрэгсэл худалдан авах ажилд 144.9-159.6 сая төгрөг буюу төсвийн 40.1 хүртэл хувь, олон нийтийн цагдаагийн урамшуулалд 28.9 хүртэл хувь, сургалт сурталчилгааны ажилд 17.7-62.4 сая төгрөг буюу 15.1 хүртэл хувийг тус тус зарцуулсан байна.

Аудитаар ГХУСАЗ-ийн зарцуулалтыг үзэхэд дараах үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна. Үүнд:

АИТХурал:

- 2023 онд АИТХурал нь ГХЗУСэргийлэх ажлын зардлыг 9 олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгалд 51.2 сая, Хорих ангид хүмүүжиж байгаа ялтнуудыг соён гэгээрүүлэх бие бялдрыг хөгжүүлэх нийгэмшүүлэх ажлын хүрээнд спорт заалны засварт 20.0 сая, Амар тайван-Аюулгүй сургууль төслийг хэрэгжүүлж 5 дугаар сургуулийн гадаад, дотоод орчин болон дотуур байрны орчныг иж бүрэн камерын нэгдсэн системд холбох 18.0 сая, Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр хамгаалах байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тоног төхөөрөмж 12.0 сая, Замын хөдөлгөөний зохион байгуулалт аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах зорилгоор 2 хурд хэмжигч худалдан авах 45.0 сая, “Нэг зам-Нэг соёл” нэгдсэн арга хэмжээнд 6.0 сая, Камерын иж бүрэн хяналтын дэлгэц холбогдох хэрэгсэл, санах ойн төхөөрөмж худалдан авах 38.9 сая, Ганзам, Сансар багуудыг “Ногоон бүс” болгоход камер худалдан авах, засварлахад 39.0 сая, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн дотуур байрыг камержуулахад 12.0 сая, Явган гарцын тэмдэг, тэмдэглэгээ 17.8 сая, ГХУСАЗСЗ-ийн 14 гишүүдийн урамшуулал 8.0 сая төгрөг болон бусад холбогдох зардалд зарцуулсан.
- 2024 онд ГХЗУСэргийлэх ажлын зардлыг 9 олон нийтийн цагдаагийн урамшуулал, эрүүл мэндийн даатгал 119.0 сая, Шүүхийн байгууллагын тоног төхөөрөмж, тавилга, эд хогшилд 30.5 сая, Цагдаагийн хэлтэст Probox автомашин 51.4 сая төгрөг мөн цагдаагийн 15 албан хаагчийг БНХАУ-ын Хөх хот, Ордос хотын цагдаагийн газарт туршлага судлахад 17.6 сая, 14 албан хаагчийг “Ногоон бүс” төслийн хүрээнд Эрдэнэт, Дархан, Өвөрхангай, Баянхонгор аймгуудад туршлага судлахад 5.4 сая, Сүмбэр сумын 2 дугаар цэцэрлэгийг камержуулахад 18.2 сая төгрөг болон бусад зардалд зарцуулсан байна.

Сумдын ИТХ нь:

Сүмбэр сум нь соёлын өвийг хамгаалах зорилгоор Боржигон өв музейд хяналтын камер 7.7 сая, 4, 5, 6 дугаар багуудын түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудаар хяналт, шалгалт хийхэд 5.6 сая, Цагдаагийн хэлтсийн байцаалтын өрөө тохижуулахад 6.8 сая, Шивээговь

сумын төвийн камеруудыг засварлах шинээр камер нэмэгдүүлэхэд 18.9 сая, Баянтал сум нь малын гэрэл ойлгогчтой хүзүүвч 0.7 сая төгрөгийг болон зардалд зарцуулсан байна. Мөн аймгийн хэмжээнд хамтарсан “Мал-мах”, “Хаялага нуур, Хэрлэн гол”-ын эргэн тойрноор эргүүл хяналтын нэгдсэн арга хэмжээнүүд тогтмол зохион байгуулжээ.

Аймгийн ИТХ-аас цагдаагийн албан хаагчдыг гадаад, дотоод туршлага судлуулах арга хэмжээнд 23.0 сая, аймаг, болон сумын ГХУАСЗЗ-ийн ажилтнуудад 8.0 сая төгрөгийн урамшуулал, цахим спортын тэмцээнд 1.0 сая, Баянтал сумын ИТХ-аас сагсан бөмбөгийн тэмцээн уралдаанд 0.9 сая, Шивээговь сумын ИТХ-аас “Аав-ээж-би” тэмцээнд 0.5 сая, Сар шинийн баярт зориулсан үндэсний “Шагайн харваа”-нд 0.2 сая, сагсан бөмбөгийн тэмцээнд 0.7 сая нийт 34.3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Шивээговь сумын ИТХ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар дээрх 1.4 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³³, 16 дугаар зүйлийн 16.5.5³⁴, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3³⁵, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5³⁶-т заасныг тус тус зөрчсөн байх тул 32.9 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг аймаг, сумын ИТХ-ын ГХУСАЗСЗ-д хүргүүлэхээр шийдвэрлэв.

В.1.2. ГХУСАХЗ-ыг зардлыг Сангийн сайдын баталсан хөтөлбөр, арга хэмжээ, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулсан байна.

В.1.3. Торгуулийн орлогоор санхүүжүүлсэн дараах арга хэмжээ нь иргэд олон нийтэд хүртээмжтэй, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Замын хөдөлгөөний зохион байгуулалт аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулах зорилгоор хурд хэмжигч
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцсон иргэд, байгууллагыг урамшуулах
- Сүмбэр сумын 5 дугаар сургууль, 2 дугаар цэцэрлэг, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн дотуур байрыг камержуулсан.
- Ганзам багийн Төмөр зам орчмыг Ногоон бүс болгох шинээр камер суурилуулсан
- Шивээговь сумын төвийн камеруудыг засварлаж шинээр камер нэмэгдүүлсэн.
- ЕБСургуулиудад “Итгэлтэй утас” байршуулсан зэрэг олон нийтэд хүртээмжтэй ажлуудыг хийсэн байна.

В.1.4. Аймаг сумдын ГХУСАХЗ-аас нийгэм, эдийн засагт эерэг нөлөө үзүүлэхүйц дараах ажлуудыг хийсэн байна.

- “Мал-мах” малын хулгайгаас сэргийлэх нэгдсэн арга хэмжээ
- Иргэдийн амралт зугаалгын үеэр Хэрлэн гол болон хаялага нуурын орчмоор эргүүл, шалгалт хийх
- Сүмбэр сумын ГХУСАЗСЗ-өөс “Итгэл” төсөл хэрэгжүүлэн архины хамааралтай сумын 20 иргэнийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10 хоног хэвтүүлэн сэтгэл зүйч багшаар өдөрт 2 цагийн сургалт хийлгэж эмчлүүлсэн.
- Сүмбэр сумын 4, 5, 6 дугаар багуудын нутаг дэвсгэрт харьяалагддаг 68 газрын 679 ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газар /Булш, хиргисүүр/-ыг ойролцоох 20 иргэнээр хамгаалуулсан зэрэг нийгэмд нөлөөтэй ажлууд хийсэн байна.

³³ 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

³⁴ 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

³⁵ 15.1.3.хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

³⁶ 46.5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийг дараах чиглэлээр зарцуулна:

В.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг Шилэн дансны цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн байна.

В.2.1. Торгуулийн орлогын зарцуулалтыг шилэн дансны цахим хуудсанд бүрэн мэдээлсэн байна.

В.2.2. Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4³⁷, 6.5.2³⁸, 6.5.4³⁹, 68.3⁴⁰-г заасны дагуу төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагааг иргэд олон нийтэд ил тод мэдээлэх хуулийн зохицуулалттай байна. Аймаг, сумын ГХУСАЗСЗ-өөс өөр өөрийн цахим хуудсанд үйл ажиллагааны талаар мэдээлсэн байна. Харин төсвийн гүйцэтгэл, зарцуулалтыг аймаг, сумын ИТХ-ын Шилэн дансны цахим хуудсанд байршуулж иргэд олон нийт танилцах боломжоор хангасан байна.

Аймгийн хэмжээнд хүү торгуулийн орлогын санхүүжилт 2023 онд 361.3 сая, 2024 онд 413.0 сая төгрөг, зардлын гүйцэтгэл 2023 онд 361.3 сая, 2024 онд 412.8 сая төгрөг бөгөөд 100% зарцуулсан байна.

Хүснэгт №1 Шилэн дансанд мэдээлсэн байдал

сая.төгрөг

№	Байгууллагын нэр	2023 он		Зөрүү	2024 он		Зөрүү
		Мэдээлбэл зохих дүн	Мэдээлсэн дүн		Мэдээлбэл зохих дүн	Мэдээлсэн дүн	
1	АИТХ	533.1	525.8	7.2	549.1	549.1	0.0
2	Сүмбэр сумын ИТХ	50.0	48.0	2.0	64.0	64.0	0.0
3	Шивээговь сумын ИТХ	10.0	9.7	0.3	48.0	48.0	0.0
4	Баянтал сумын ИТХ	10.0	10.0	0.0	10.0	10.0	0.0
Нийт дүн		603.1	593.6	9.5	671.1	671.1	0.0

(Эх сурвалж: Шилэн дансны цахим хуудсанд хийсэн тулгалт)

Хүснэгтээс харахад: Шилэнд дансны мэдээллийг 98%-тай байршуулсан байна.

АИТХ-аас олон нийтэд хийгдсэн сургалт, сурталчилгааны ажлын тайланг дараах байдлаар хийгдсэн байна. 2023 онд аймгийн засаг даргын А/41 дүгээр захирамжаар “Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ”-г 3 зорилтын 12 багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 95 хувьтай хэрэгжүүлсэн байна. Тус ажлын хүрээнд хууль тогтоомж сурталчлах сургалтыг 14 удаа зохион байгуулж 469 албан хаагч, ААН, ЕБС-ын багш нар хамрагдсан байна. Мөн 18 төрлийн постер бэлтгэн 842 иргэний хандалт хийж, 246 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн байна. Хөдөөгийн багийн 186 малчин өрхөөр орж туслах малчинтай байгуулах гэрээ болон эрх зүйн мэдээллийг өгч 130 ширхэг гарын авлага тараасан байна. Мөн АИТХ, аймгийн Цагдаагийн хэлтсийн пэйж хуудсанд байршуулж, олон дагагчтай фэйсбүүк хаягт түгээх ажлыг зохион байгуулснаар 84320 удаа шэйр хийж, 3486 удаа лайк дарж, 671791 удаагийн хандалт авсан байна.

2024 онд салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд 4 зорилтын 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 35 арга хэмжээг хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 97.2 хувьтай байна. Тус ажлын хүрээнд хууль тогтоомж сурталчлах сургалт, тэмцээн уралдааныг 22 удаа зохион байгуулж 5590 хүн хамрагдаж, эрх зүйн мэдлэг мэдээлэлтэй холбоотой 4250 ширхэг гарын авлага бэлтгэж тараасан байна. Хөдөөгийн багийн 130 малчин өрх, хөдөөгийн 4 багийн өдөрлөгт оролцож хууль бус ан агнуур, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах болон эрх зүйн мэдээллийг өгч 1650 ширхэг гарын авлага тараасан байна. Мөн АИТХ, аймгийн Цагдаагийн хэлтсийн пэйж хуудсанд байршуулж, олон дагагчтай фэйсбүүк хаягт түгээх ажлыг зохион байгуулснаар 47,115 удаа шэйр хийж, 4,325 удаа лайк дарж, 77,379 удаагийн хандалт авсан байна.

³⁷ 5.1.4.ил тод байдлыг хангасан байх;

³⁸ 6.5.2.төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;

³⁹ 6.5.4.төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах;

⁴⁰ 68.3.Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Зөвлөлөөс баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

В.2.3. Хүү, торгуулийн орлогын зарцуулалттай холбоотой ил тод байдалд иргэд, төрийн бус байгууллага, хяналтын зөвлөл зэрэг оролцогч талууд үнэлгээ өгч, санал хүргүүлээгүй байна.

БҮЛЭГ Г

Г. Торгуулийн бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан байхгүй, орлогын бүрдүүлэлтэд эрх бүхий байгууллага албан тушаалтан хяналт тавьж байгаа боловч зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, иргэд олон нийт хяналт тавих хяналтын тогтолцоо бүрдээгүй байна.


Г.1. Торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангүй байгаагаас төрийн байгууллага бүр тус тусдаа мэдээллийн сан бүрдүүлсэн байна.

Г.1.1. Говьсүмбэр аймгийн хэмжээнд торгуулийн оногдуулах эрх бүхий 25 байгууллага байна. Улсын хэмжээнд торгуулийн мэдээллийн нэгдсэн сан байхгүйгээс байгууллагууд тус бүртээ харилцан адилгүй байдлаар мэдээллийн сан бүрдүүлж байна. Тус тусдаа мэдээллийн сан бүрдүүлж байгаагаас шалтгаалан төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох боломж бүрэн бүрдээгүй байна.

Г.1.2. Засгийн газрын 2021.05.12-ны өдрийн 135-р тогтоолоор “Шийтгэлийн болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт хэрэглэх журам”-ыг баталсан байна. Говьсүмбэр аймагт торгох шийтгэл оногдуулах эрх бүхий 25 байгууллагаас 14 байгууллагын ЭБАТ-нууд 2023 онд 25645, 2024 онд 31775 зөрчил илрүүлж торгох шийтгэл оногдуулсан байна. Үүний 99.3-99.7 хувийг цагдаагийн торгууль эзэлж байгаа бөгөөд торгуулийг төлбөрийн системээр тавьж байна.

Г.1.3. Торгуулийг цахим системээр төлөх нөхцөлийг бүрдүүлсэн нь орлого бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 18 Цахим системээр төлөгдсөн торгуулийн тоо



(Эх сурвалж: Говьсүмбэр аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээ)

Замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн болон татварын торгуулиудыг цахимаар шалгах, төлөх боломжтой болсон боловч бусад байгууллагын ЭБАТ-наас оногдуулсан торгуулийг E-Mongolia, Gerege болон бусад платформуудаар дамжуулан төлөх нөхцөл бүрэн бүрдээгүй байна.

Г.2. Торгуулийн орлогын бүрдүүлэлтэд эрх бүхий байгууллага албан тушаалтан хяналт тавьж байгаа боловч, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, иргэд олон нийт хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.

Г.2.1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт⁴¹, 9.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт⁴² заасны дагуу хугацаандаа төлөөгүй торгуулийг шүүхэд хүсэлт гарган албадан гүйцэтгүүлэхээр заасан. Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2024 оны жилийн эцсийн байдлаар Цагдаагийн хэлтсийн газар дээр нь хялбаршуулсан зөрчилд оногдуулсан торгууль 230.2 сая төгрөг, Байгаль орчны газрын 2 зөрчлийн 10.0 сая төгрөг, ХГБХХГ-ын 0.3 сая төгрөгийн торгуулийн орлого төсөвт төвлөрүүлээгүй байна. Цагдаагийн хэлтсийн төлөгдөөгүй торгууль нь 13 хувийг эзэлж байна. Харин Байгаль орчны газар 10.0 сая төгрөгийг төлүүлэхээр Шүүхэд хүсэлт гаргасан байна.

Г.2.2. Зөрчил шалган шийдвэрлэх тухай 7.5 дугаар зүйлийн 1⁴³, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8⁴⁴-т заасны дагуу торгуулийн орлогын бүрдүүлэлт болон зарцуулалтад хяналт тавих байгууллага, албан тушаалтныг тодорхойлжээ.

Орлого бүрдүүлэлтэд тавих хяналт:

ЭБАТ-нуудын үйл ажиллагаа прокурорын зөвшөөрөл болон хяналт дор явагддаг тул энэ нь орлого бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлж байна. Говьсүмбэр аймгийн Прокурорын газраас ЭБАТ-нуудын 2023, 2024 оны зөрчлийн хэргийн баримт материалыг татан авч хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Зарцуулалтад тавих хяналт:

ГХУСАХЗ-ын зарцуулалтад хуулийн 46.8-т заасан төрийн аудитын байгууллагаас бусад эрх бүхий этгээд хяналт хэрэгжүүлээгүй байна. Төрийн аудитын байгууллагаас ГХУСАХЗ-ын зарцуулалттай холбоотой дараах зөрчлийг илрүүлжээ.

1. ГХУСАХЗ-аас 12ш энгэрийн камер худалдан авч 10 ширхэгийг Цагдаагийн хэлтэст бүртгүүлж 1.0 сая төгрөгийн 2ш энгэрийн камерыг бүртгэж тайлагнаагүй.
2. ГХУСАХЗ-аас худалдан авсан 11.0 сая төгрөгийг хяналтын камерыг бүртгэж тайлагнаагүй.
3. ГХУСАХЗ-аас хяналтын камер суурилуулах ажлын ХАА-г зохион байгуулахдаа худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй 96.0 сая төгрөгийн худалдан авалтыг 5 хувааж босго үнэд багтаан шууд худалдан авалт хийсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас 2023 оны үйл ажиллагаанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах албан шаардлага өгч хэрэгжилтийг тооцсон байна.

Г.2.3. Засгийн газрын 2023 оны 6 дугаар тогтоолоор “хяналт улсын байцаагчийн эрх олгох журам”-ыг баталсан бөгөөд уг журмын 1.4⁴⁵-т заасны дагуу орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлэх нэгжийн даргад ахлах байцаагчийн эрхийг, хяналт тавих албан тушаалтанд улсын байцаагч эрх олгохоор заасан. Мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т “зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах” гэж

⁴¹ 7.4.5 “зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ”

⁴² 9.3.2 “зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ”

⁴³ 7.5.1 “эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна”

⁴⁴ 46.8.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина.

⁴⁵ 1.4.Хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны төв байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн хяналт шалгалт хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан хаагч, стандарт, хэмжил зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, хуульд заасан бол хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий төрийн захиргааны бусад байгууллагын хяналт шалгалтын чиг үүргийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын бүтцийн нэгжийн дарга, хуулиар эрх олгосон байгууллагын болон хяналт шалгалтын чиг үүргийг шилжүүлж авсан албан тушаалтанд болон орон нутаг дахь хяналт шалгалтын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжийн даргад тус тус улсын ахлах байцаагчийн эрхийг олгоно.

заасан бөгөөд Говьсүмбэр аймагт торгох шийтгэл оногдуулсан 14 байгууллагын удирдах албан тушаалтнууд дээрх чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Г.2.4. Торгуулийн орлогын бүрдүүлэлт зарцуулалтад хөндлөнгийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлээгүй байна. Энэ нь ГХЗУСТХ-ийн 38 дугаар зүйлийн 38.1⁴⁶ 38.2.6⁴⁷-т төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох гэж заасан боловч хэрэгжилтийг хэрхэн хангуулах зохион байгуулалтын дүрэм, журмыг батлаагүйтэй холбоотой байна.

Гүйцэтгэлийн аудитаар нийт 163.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 32.9 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 130.2 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, Нийслэл дэх Төрийн аудитын газар уламжлах 3 саналыг хүргүүлээ.

⁴⁶ 38.1.Төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад олон нийтийн оролцоог хангана.

⁴⁷ 38.2.6.гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн зарцуулалтад олон нийтийн оролцоо, хяналтыг бий болгох.



ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагууд хүүгийн орлогыг төлөвлөөгүй боловч торгуулийн орлогыг төлөвлөлт хийх үеийн нөхцөл байдалд үндэслэн төлөвлөсөн байна.
2. Торгуулийн орлого жил бүр баталсан төлөвлөгөөнөөс 39-78 хувиар давж биелсэн боловч орлого давж байгаа шалтгаан нөхцөлийг дүгнээгүй, сумдын төсөвт торгуулийн орлогыг төлөвлөөгүй байна.
3. Торгуулийн орлогын хууль эрх зүйн орчны уялдаа холбоог сайжруулж, Төсвийн тухай хуульд нийцүүлэх шаардлагатай байна.
4. 2023,2024 онд торгох шийтгэл оногдуулсан торгуулийн орлогын 87 хувь нь төсөвт төвлөрсөн бөгөөд торгуулийн орлогын төлөвлөгөө жил бүр 39-78 хувиар давж биелсэн байна.
5. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хууль, журмын дагуу хуваарилаагүй байна.
6. Аймаг, сумын ГХУСАХЗ-аас гадаад, дотоод туршлага судлах, тэмцээн уралдаан зохион байгуулах арга хэмжээнд 34.3 сая төгрөгийг зарцуулсан байна.
7. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг Шилэн дансны цахим хуудсаар дамжуулан мэдээлсэн байна
8. Торгуулийн орлого бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангүй байгаагаас төрийн байгууллага бүр тус тусдаа мэдээллийн сан бүрдүүлсэн байна.
9. Торгуулийн орлогын бүрдүүлэлтэд эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавьж байгаа боловч, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, иргэд олон нийт хяналт тавих тогтолцоо бүрдээгүй байна.

ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД:

1. Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.3⁴⁸, 22.6.4⁴⁹, 23 дугаар зүйлийн 23.9⁵⁰, 23.9.2⁵¹ заасны дагуу торгуулийн орлогыг сумын татварын бус орлогын эх үүсвэрт төлөвлөх, торгуулийн орлогыг зөрчил шалган шийдвэрлэсэн сумдын төрийн сангийн холбогдох дансанд төвлөрүүлж Төсвийн тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх
2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг хуульд заасан хувь хэмжээгээр тооцон төсөвт тусгах

СУМДЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА НАРТ:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2⁵²-т заасны дагуу гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хийхдээ гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, хууль сахиулах чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах

СУМДЫН ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж сумын төсөвт торгуулийн орлогыг төлөвлөх, тухайн зөрчлийг шийдвэрлэсэн газар нутгийн байршлаар нь харьяа төрийн сангийн дансанд торгуулийн орлогыг төвлөрүүлэх

Дээрх зөвлөмжийг 2026 оны 01 дүгээр сарын 10-ны дотор биелүүлж, хэрэгжилтийг ирүүлнэ үү.

⁴⁸ 22.6.3.төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх;

⁴⁹ 22.6.4.төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;

⁵⁰ 23.9.Сум, дүүрэг, орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ:

⁵¹ 23.9.2.орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого;

⁵² 20.2.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөө нь олон нийтийн хэрэгцээ, шаардлага, гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээ, цаашдын төлөв байдал, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн байна.

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ САНАЛ

Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлуулах саналтай байна. Үүнд:

1. Төсвийн тухай хуулиар торгуулийн орлого нь орон нутгийн төсвийн орлогод хамаарах боловч Зөрчлийн тухай хуулиар торгуулийг улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан байна. Үүнээс шалтгаалж 8 байгууллага 27.5 сая төгрөгийн торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлжээ. Иймд хууль тогтоомжийн харилцан уялдаагүй батлагдсан байдлыг нэгдсэн тайланд дурдаж холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах
2. Зөрчлийн тухай хууль, Авто замын тухай хуулиар замын хөдөлгөөний тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчилд оногдуулсан торгуулийн орлогоос Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын эх үүсвэр, Авто замын сангийн эх үүсвэрт тус тус хуваарилахаар хуульчилсан боловч Авто замын тухай хуулийн 25.2.4-т төвлөрүүлсэн орлогын хэдэн хувийг зардлын эх үүсвэрт тусгах нь тодорхой бус байгаа тул арга, аргачлал, хувь хэмжээг тодорхой болгох саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах
3. 1997.12.05-ны өдрийн баталсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль 2019 онд хүчингүй болсон бөгөөд шинэчилсэн хуулийг 2020 оноос эхлэн мөрдөж байна. Шинэчлэн баталсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-т “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг санхүүжүүлэх хөрөнгийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.” гэж заасан боловч уг журмыг шинэчлэн батлаагүй байх тул Монгол Улсын хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998.04.10-ны өдрийн 88/152 дугаар тушаал баталсан журмыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлах саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд уламжлах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Найрамдал хотхон, 3 дугаар баг,
Сүмбэр сум, Говьсүмбэр аймаг, 42015
Утас/Факс: (976) 7054 3005,
Цахим шуудан: zdtg.gsa@gmail.com,
Цахим хуудас: www.govisumber.gov.mn

2025.08.04 № 8/774
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

“Хүү, торгуулийн орлогын 2023, 2024 онуудын
бүрдүүлэлт, зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитаар илэрсэн алдаа,
зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах болно.

Хавсралт хуудастай.



Т.БАТ-ЭРДЭНЭ

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Шалгагдагч байгууллагаас тайлангийн төсөлд санал ирүүлээгүй тул тайланг эцэслэн дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/23

Чойр

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар зүйлийн 18.9, 18.10 дахь заалт, "Эрх шилжүүлэх тухай" 2023 оны А/102 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүү,торгуулийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт"-д хийсэн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газар, аймаг, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон Засаг дарга нарт хүргүүлэхийг ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Б.Соёлмаа нарт даалгасугай.

3. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хугацаанд нь хэрэгжүүлж, биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймаг, сумын ГХУСАЗСЗ болон Засаг дарга нарт зөвлөсүгэй.

4. Аудитын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Б.Соёлмаа нарт үүрэг болгосугай.

5. Аудитын ажлын болон нотлох баримтыг 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн дотор архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор Б.Дарханбат, аудитор Б.Соёлмаа нарт даалгасугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (Г.Наранбаяр)-т даалгасугай.


Б.САРАНТУЯА